Гадаад валютын урт хугацаат өр төлбөрт ханшийн тэгшитгэлийг тухай бүр хийж, тайлант үеийн олз, гарзаар тайлагнана. Зээлдүүлэгч бүрээр нэрийн данс нээн бүртгэж, хяналтын дансны үлдэгдэлтэй тохируулна.

Зээлдүүлэгчтэй байгуулсан гэрээний дагуу зээл мөнгөөр орж ирсэн үед:

Дт: Мөнгөн хөрөнгийн данс
Кт: Урт хугацаат өр төлбөр

Гэрээний дагуу урт хугацаат зээлийг төлөх үед:

Дт: Урт хугацаат өр төлбөр
Кт: Мөнгөн хөрөнгийн данс

Гэрээнд заасан хувь хэмжээгээр зээлийн хүүг сар бүр хуримтлуулан тооцож тайлант үеийн зардлаар бүртгэнэ.

Дт: Банк, санхүүгийн байгууллагад төлсөн зээлийн хүүгийн зардал
Кт: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг

Хуримтлуулж тооцсон болон хуримтлуулж тооцоогүй зээлийн ашигласан хугацаанд ногдох хүүгийн төлбөрийг хийхэд:

Дт: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг (хуримтлуулж бүртгэсэн дүнгээр)
Дт: Банк, санхүүгийн байгууллагад төлсөн зээлийн хүүгийн зардал (ашигласан хугацаанд ногдох хуримтлуулаагүй дүнгээр)
Кт: Мөнгөн хөрөнгийн данс (төлсөн дүнгээр)

Урт хугацаат зээлийн үлдэгдлийг төлөх хугацаа 12 сараас бага болсон тохиолдолд богино хугацаат зээл рүү шилжүүлэн бүртгэнэ.

Дт: Урт хугацаат зээл
Кт: Богино хугацаат зээл

## 3.6 Хойшлогдсон татварын өр төлбөр

### 3.6.1 Хойшлогдсон татварын өр төлбөрт хамрагдах зүйлс

Хойшлогдсон татварын өр төлбөр гэдэг нь татвар ногдох түр зөрүүтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед төлөх орлогын албан татварын өглөгийн дүн юм. Түр зөрүү гэдэг нь баланс дахь хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнэ ба татварын суурь хоёрын хоорондох зөрүү юм.

### 3.6.2 Хойшлогдсон татварын өр төлбөрийн бүртгэл

Татвар ногдох түр зөрүү үүссэн үед:

Дт: Орлогын албан татварын зардал
Кт: Орлогын албан татварын өглөг
Кт: Хойшлогдсон татварын өглөг

Хойшлогдсон татварын өглөгийг буцаах үед:

Дт: Хойшлогдсон татварын өглөг
Кт: Орлогын албан татварын өглөг

## ДӨРӨВ. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

### 4.1.1 Өөрийн хөрөнгөд хамрагдах зүйл

Өөрийн хөрөнгө нь гишүүдийн оруулсан хувь хөрөнгө болон нөөцийн сан, хадгаламж хамгаалалтын сан, бусад сан, хандив, тусламж, хуримтлагдсан орлогын нийлбэр юм.

### 4.1.2 Үнэлгээ

Өөрийн хөрөнгийг нэрлэсэн үнээр бүртгэнэ.

### 4.1.3 Санхүүгийн тайланд тусгах

Балансад "Өөрийн хөрөнгө"-ийг дараах төрлөөр ангилж бүртгэнэ.

- Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө
- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл
- Хоршоологчдын өмч (нөөцийн сан, хадгаламж хамгаалалтын сан, бусад сан, хандив, тусламж, хуримтлагдсан орлого)

### 4.1.4 Өөрийн хөрөнгийн бүртгэл

**<u>Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</u>**

ХЗХ-нд гишүүнээр элсэхэд оруулах тухайн ХЗХ-ны дүрмээр тогтоосон мөнгөн хөрөнгө юм.

Хуулийн дагуу болон ХЗХ-ны тэргүүлэгчдийн зөвлөл, бүх гишүүдийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу гарсан өөрчлөлтийг (шинээр гишүүн элсүүлэх, ногдол ашгаар хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх гэх мэт) гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн дансанд тусгана.

Гишүүн бүрээр оруулсан хувь хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх ба хяналтын дансны үлдэгдэлтэй нийлж тохируулна.

ХЗХ-ны нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн дээд хэмжээ нь нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн 10 хувиас хэтэрч болохгүй.

Гишүүн ХЗХ-нд хувь хөрөнгө оруулах үед гишүүнээр элсүүлэх тухай ХЗХ-ны эрх бүхий удирдлагын шийдвэр, хувь хөрөнгө нийлүүлсэн баримтыг үндэслэн:

Дт: Мөнгөн хөрөнгийн данс
Кт: Гишүүний оруулсан хувь хөрөнгө

Гишүүн ХЗХ-ны гишүүнчлэлээс гарах үед ХЗХ-ны эрх бүхий удирдлагын шийдвэрийг үндэслэн:

Дт: Гишүүний оруулсан хувь хөрөнгө
Кт: Мөнгөн хөрөнгийн данс

**Хандив, тусламж**

ХЗХ нь гишүүд болон иргэн, бусад хуулийн этгээдээс авсан хандив, тусламжийг доорх байдлаар бүртгэнэ.

Дт: Мөнгөн хөрөнгө эсвэл хөрөнгийн данс
Кт: Хандив, тусламж

**Тусгай зориулалтын сангууд**

ХЗХ-г хөгжүүлэх, болзошгүй алдагдлыг нөхөх, гишүүдийн хадгаламжийг хамгаалах, гишүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, гишүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор тусгай зориулалтын санг цэвэр орлогоос байгуулна. Эдгээр сангуудад хуваарилах хөрөнгийн хэмжээ, сангийн зарцуулалтыг ХЗХ-ны бүх гишүүдийн хурлаар батална.

Бүх гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн цэвэр орлогоос тусгай зориулалтын сан байгуулахад:

Дт: Цэвэр орлого
Кт: Нөөцийн сан эсвэл бусад сан

ХЗХ гишүүдийнхээ хадгаламжийн баталгааг хангах хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу даатгагдах хадгаламжийн дүнгээс илүү гарсан дүнгийн тодорхой хувиар ХЗХ-ны дүрэм, журамд заасны дагуу хадгаламж хамгаалалтын санг байгуулна.

Дт: Цэвэр орлого
Кт: Хадгаламж хамгаалалтын сан

Сангаас зарцуулалт хийсэн тохиолдолд:

Дт: Нийгмийн хөгжлийн сан
Кт: Мөнгөн хөрөнгийн данс

Алдагдалтай ажилласан ХЗХ эдгээр сангуудыг байгуулахгүй бөгөөд алдагдлын хэмжээгээр нөөцийн санг хорогдуулна.

Дт: Нөөцийн сан
Кт: Хуримтлагдсан алдагдал

**Тайлант үеийн цэвэр орлого, алдагдал:**

ХЗХ нь тайлант хугацааны ашиг, алдагдлыг хуваарилах хүртэл тайлант жилийн цэвэр орлого, алдагдал дансанд бүртгэнэ. Бүх гишүүдийн хурлаас тухайн жилийн ашиг хуваарилах талаар гаргасан шийдвэрийн дагуу тусгай зориулалтын сангуудад хуваарилж, үлдэх хэсгийг гишүүдэд ногдол ашгийн хэлбэрээр хуваарилна. Үлдсэн хэсгийг хуримтлагдсан орлого дансанд шилжүүлж бүртгэнэ.

ХЗХ ашигтай ажилласан бол жилийн эцэст цэвэр ашгийн дүнгээр:

Дт: Орлого, зардлын нэгдсэн данс
Кт: Цэвэр орлого

ХЗХ алдагдалтай ажилласан бол жилийн эцэст алдагдлын дүнгээр:

Дт: Цэвэр алдагдал
Кт: Орлого, зардлын нэгдсэн данс

Цэвэр орлогыг хуваарилаад үлдсэн орлогыг хуримтлагдсан орлогод шилжүүлэхэд:

Дт: Цэвэр орлого
Кт: Хуримтлагдсан орлого

**Ногдол ашгийн бүртгэл**

Тайлант жилийн ашгаас гишүүдэд оруулсан хувь хөрөнгийн хэмжээ, гишүүнээр элссэн хугацаа зэргийг харгалзан ХЗХ-ны дүрэм болон дотоод журмын дагуу ногдол ашиг хуваарилна.

Бүх гишүүдийн хурлаас гишүүдэд ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн үед зарласан хэмжээгээр:

Дт: Хуримтлагдсан орлого
Кт: Ногдол ашгийн өглөг

Ногдол ашгийг мөнгөөр олговол:

Дт: Ногдол ашгийн өглөг
Кт: Мөнгөн хөрөнгийн данс

ХЗХ-ны гишүүн ногдол ашгаараа оруулсан хувь хөрөнгөө нэмэгдүүлэхийг хүсвэл:

Дт: Ногдол ашгийн өглөг
Кт: Гишүүний оруулсан хувь хөрөнгө

Гишүүн тус бүрээр олгосон ногдол ашгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.

**Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл**

Үндсэн хөрөнгийг дахин үнэлснээр үндсэн хөрөнгийн үнэ нэмэгдвэл дахин үнэлгээний нэмэгдэл дансаар бүртгэнэ. Дахин үнэлгээний нэмэгдлийн бүртгэлийг зааврын хоёрдугаар бүлэгт харуулав.

## ТАВ. ОРЛОГО БА ЗАРДАЛ

**Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх**

ХЗХ орлого, зардлыг бүртгэлийн аккруэл суурийн дагуу тооцож, бүртгэнэ. Бүртгэлийн аккруэл суурь нь мөнгө хүлээн авсан эсвэл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх арга юм.

### 5.1 Орлого ба олз

#### 5.1.1 Орлого ба олзод хамрагдах зүйлс

Орлого нь ХЗХ-ны тайлант хугацаан дахь ердийн үйл ажиллагаанаас бий болсон бөгөөд гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бусад шалтгаанаар өмчийн өсөлт хэлбэрээр илэрсэн, эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал юм.

Бусад орлого ба олз нь ХЗХ-ны байнгын бус буюу гэнэтийн ажил, үйлчилгээнээс түүнчлэн гишүүдийн орлого буюу хөрөнгө оруулалтаас бусад тухайн тайлант хугацаанд ХЗХ-нд нөлөөлөх бүх ажил гүйлгээ, үйл явдлын үр дүнд өмчид гарсан цэвэр өсөлт юм.

#### 5.1.2 Орлогын ангилал

Орлогыг агуулгаас нь хамааруулж:

А. Үйл ажиллагааны орлого
Б. Бусад орлого гэж ангилна.

Үйл ажиллагааны орлогыг:

1. Хүүгийн
2. Хүүгийн бус орлого гэж ангилна.

#### 5.1.3 Орлогын бүртгэл

**А. Үйл ажиллагааны орлого**

ХЗХ гэрээний үндсэн дээр гишүүддээ олгосон зээл, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг тэдэнд ашиглуулсны хариу төлбөрт хүлээн авч байгаа орлогыг хүүгийн орлого гэнэ.

Тайлант хугацааны зээлийн хүү болон банкнаас авсан хүүгийн орлогыг тухайн банк, гишүүнтэй байгуулсан гэрээнд заасан хувь хэмжээгээр хуримтлуулж бүртгэнэ. Хүүгийн орлогын бүртгэлийг зааврын хоёрдугаар бүлгийн 2-т тусгасан болно.

Орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.

ХЗХ нь дараах нөхцөл бүрдсэн үед хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрнө:

- тухайн ажил гүйлгээний эцсийн үр өгөөжийг ХЗХ хүртэх магадлалтай;
- орлогын дүнг найдвартай хэмжин тооцох боломжтой.

ХЗХ нь Хорооноос зөвшөөрсөн, хууль тогтоомжоор хориглоогүй санхүүгийн бусад ажил, үйлчилгээг эрхэлж болно.

Дт: Мөнгөн хөрөнгийн данс
Кт: Санхүүгийн түрээсийн орлого

Дт: Мөнгөн хөрөнгийн данс
Кт: Төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээний орлого

Дт: Мөнгөн хөрөнгийн данс
Кт: Цахим төлбөр тооцооны төлөөлөгчөөр ажиллах үйлчилгээний орлого

Гишүүдээс хүлээн авсан үйлчилгээний шимтгэл, татвар, хураамжийн орлогыг орлого орсон тухай бүр бүртгэнэ.

Дт: Мөнгөн хөрөнгийн данс
Кт: Холбогдох орлогын данс

**Б. Бусад орлого ба олз**

Үйл ажиллагаатай холбогдсон үндсэн бус үйл ажиллагаанаас болон гэнэтийн ажил гүйлгээнээс орох орлого, олзыг эдгээр орлогуудад хамааруулна. Тухайлбал:

Үндсэн хөрөнгө борлуулсны олзыг бүртгэхэд:

Дт: Мөнгөн хөрөнгийн данс эсвэл Авлага
Кт: Үндсэн хөрөнгө борлуулсны олз

## 5.2 Зардал ба гарз

### 5.2.1 Зардал ба гарзад хамрагдах зүйлс

Үйл ажиллагааны зардал нь тайлант хугацааны туршид үндсэн үйл ажиллагааг явуулахын тулд бусад үйл ажиллагааг гүйцэтгэснээр хөрөнгө буурах, өр төлбөр үүсэх явдал юм.

Бусад зардал ба гарз нь ХЗХ-ны байнгын бус буюу гэнэтийн ажил гүйлгээнээс тухайн тайлант хугацаанд ХЗХ-нд нөлөөлөх бүх ажил гүйлгээ, үйл явдлын үр дүнд өмчид гарсан бууралт юм.

### 5.2.2 Зардлын ангилал

А. Үйл ажиллагааны зардал
Б. Бусад зардал ба гарз гэж ангилна.

Үйл ажиллагааны зардлыг:

1.Хүүгийн зардал
2.Үйл ажиллагааны бусад зардал гэж ангилна.

### 5.2.3 Зардлын бүртгэл

Хүүгийн зардал нь ХЗХ-ны зээл, бусад үйлчилгээний эх үүсвэрт ашиглахын тулд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлбөр буюу өртөг юм. Хүүгийн зардлыг татан төвлөрүүлсэн хөрөнгийн төрлөөр ангилж бүртгэнэ.

Хадгаламжийн болон банк, санхүүгийн байгууллагад төлөх зээлийн хүүгийн төлбөрийн бүртгэлийг зааврын гуравдугаар бүлгийн 3-р зүйлд тусгасан болно.

Үйл ажиллагааны бусад зардал гэдэг нь үйлчилгээний өртөгт шууд хамаарагдахгүй болович үйл ажиллагаатай холбогдон өдөр тутам гарч байгаа үйлчилгээ, удирдлагын зардал юм.

Үйл ажиллагааны болон бусад зардлыг зардлын төрлөөр ангилж бүртгэнэ. Тухайлбал:

Харилцаа, холбооны зардлыг ирсэн нэхэмжлэлийг үндэслэн:

Дт: Харилцаа, холбооны зардал
Кт: Мөнгөн хөрөнгийн данс эсвэл Өглөг

Цахилгаан, эрчим хүч, дулаан, цэвэр, бохир ус хэрэглэсний төлбөрийг:

Дт: Ашиглалтын зардал
Кт: Мөнгөн хөрөнгийн данс эсвэл Өглөг

Шатахуун болон тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар үйлчилгээний зардлыг жолоочийн тооцоо, нэхэмжлэх, бусад баримтыг үндэслэн:

Дт: Тээвэр, шатахууны зардал
Кт: Мөнгөн хөрөнгийн данс эсвэл Өглөг

Банк, санхүүгийн байгууллагад төлсөн шимтгэл, хураамжийг банкны хуулга, бусад баримтыг үндэслэн:

Дт: Санхүүгийн хураамж, банкны шимтгэлийн зардал
Кт: Мөнгөн хөрөнгийн данс эсвэл Өглөг

Хадгаламжийн даатгалын хураамжийг хадгаламжийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс тогтоосон хувь хэмжээний дагуу:

Дт: Хадгаламжийн даатгалын хураамж
Кт: Мөнгөн хөрөнгийн данс эсвэл Өглөг

Мэргэжлийн байгууллагын үйлчилгээ болон хөндлөнгийн хяналтын зардлыг тэдэнтэй байгуулсан гэрээ, нэхэмжлэлийг үндэслэн:

Дт: ХЗХ-дын үндэсний холбооны гишүүний татвар эсвэл хөндлөнгийн хяналтын зардал
Кт: Мөнгөн хөрөнгийн данс эсвэл Өглөг

ХЗХ-дын үндэсний холбооноос үзүүлж буй тогтворжилтын үйлчилгээний шимтгэлийг:

Дт: Тогтворжилтын үйлчилгээний шимтгэл
Кт: Мөнгөн хөрөнгийн данс эсвэл Өглөг

Зарцуулсан хангамжийн зүйл, үнэ бүхий зүйлсийг нярвын тайлангаар:

Дт: Бичиг хэрэг болон холбогдох бусад зардал
Кт: Хангамжийн зүйл

Харуул хамгаалалтын зардлыг гэрээ, нэхэмжлэх, бусад зардлын баримтыг үндэслэн доорх байдлаар бүртгэнэ:

Дт: Харуул, аюулгүй байдлын зардал
Кт: Мөнгөн хөрөнгийн данс эсвэл Өглөг

**Цалин, хөнгөлөлт, нийгмийн даатгалын зардал**

ХЗХ нь Монгол Улсын хуулийн дагуу үндсэн болон түр ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ байгуулж түүнд тодорхойлсон цалинг сар бүр тооцож олгох ба татвар, шимтгэлийн тооцоог тухай бүр хийж, татварын болон нийгмийн даатгалын байгууллагуудад тайлагнах ёстой.

Цалинг тооцооны хүснэгт үндэслэн олгохоор тооцсон цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын дүнгээр:

Дт: Цалингийн зардал
Кт: Цалингийн өглөг
Кт: НДШ-ийн өглөг
Кт: ХХОАТ-ын өглөг

Эдгээр болон бусад суутгалуудыг хийсний дараа цалинг олгох үед:

Дт: Цалингийн өглөг
Кт: Бэлэн мөнгө

ХЗХ нь гэрээт ажиллагсдын цалингийн тооцоо, бүртгэлийг үндсэн ажилчдын нэгэн адил хийнэ.

Харин хувь хүнээр үндсэн болон өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдолгүй, нэг удаагийн шинж чанартай ажил гүйцэтгүүлбэл (жишээ нь: үндсэн хөрөнгийн засвар) ХХОАТ-ын суутгал хийж, ажлын хөлсийг олгоно.

Дт: Засварын зардал (нийт ажлын хөлсний дүнгээр)
Кт: Мөнгөн хөрөнгийн данс (гарт нь олгох дүнгээр)
Кт: ХХОАТ-ын өглөг (суутгах орлогын татварын дүнгээр)

Үндсэн болон гэрээт ажиллагсад, хувь хүнд олгосон ажлын хөлс, худалдаж авсан бараа, үйлчилгээний үнээс суутгасан ХХОАТ-ыг харьяа татварын байгууллагад шилжүүлж:

Дт: ХХОАТ-ын өглөг
Кт: Мөнгөн хөрөнгийн данс

гэж бүртгэн тайлант үеийн эцэст тайлан гаргаж, тооцоо нийлнэ.

ХЗХ нь үндсэн болон түр гэрээт ажиллагсдад олгосон цалин, хөнгөлөлтөөс тооцож нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг байгууллагаас төлөх ёстой.

Дт: НД, ЭМД-ын шимтгэл
Кт: НД, ЭМД-ын шимтгэлийн өглөг

Ажиллагсдад олгосон цалин, хөнгөлөлтөөс суутгасан болон тэдгээрээс тооцож байгууллагын зардлаар хуримтлуулж бүртгэсэн НД, ЭМД-ын шимтгэлийг харьяа нийгмийн даатгалын байгууллагад төлж:

Дт: НД, ЭМД-ын шимтгэлийн өглөг
Кт: Мөнгөн хөрөнгийн данс

гэж бүртгэн тайлант үеийн эцэст тайлан гаргаж, тооцоо нийлнэ.

ХЗХ дотоод журам, эрх бүхий удирдлагын шийдвэрээр ажилчдад тогтмол болон цаг үеийн хөнгөлөлт үзүүлж болно.

Хөнгөлөлт олгох үед олгохоор тооцсон дүнгээр:

Дт: Хөнгөлөлтийн зардал
Кт: Цалингийн өглөг

Ажилчдад олгосон хөнгөлөлтөөс НДШ-ийг цалингийн нэгэн адил тооцож төлнө.

**<u>Бусад зардлын бүртгэл</u>**

Бусад зардал, гарз гэдэг нь ХЗХ-ны туслах үйл ажиллагаа эсвэл нэг удаагийн ажил гүйлгээний үр дүн болон гарсан зардал юм. Эдгээрийг голчлон холбогдох орлогыг хассан цэвэр дүнгээр бүртгэнэ.

Тухайлбал: эрх зүйн маргааны улмаас нөхөн төлбөр, торгууль төлбөл:

Дт: Торгууль, нөхөн төлбөрийн зардал
Кт: Мөнгөн хөрөнгийн данс

ХЗХ-ны буруутай үйл ажиллагаатай холбогдон төлсөн торгууль, алданги, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлсөн төлбөрийг Үйл ажиллагааны үр дүнгийн тайланд тусгах боловч орлогын албан татварын тооцоонд татвар ногдох орлогоос хасагдах зардалд оруулахгүй.

**<u>Орлогын албан татварын зардал</u>**

ХЗХ нь татвар ногдох орлогоо Монгол Улсын татварын хуулийн дагуу тооцон тухайн дүнгээс тайлангийн үед ногдох орлогын албан татварын зардлыг тодорхойлно.

Төсөвт урьдчилан төлсөн татварыг балансын бусад эргэлтийн хөрөнгийн нэг зүйл ангиар үзүүлнэ.

Тайлант үеийн дундуур орлогын албан татварыг урьдчилж төлбөл:

Дт: Урьдчилж төлсөн орлогын албан татвар
Кт: Мөнгөн хөрөнгийн данс

Тайлант үеийн эцсээр орлогын албан татварын тооцоог хийж, татварын зардлыг бүртгэхэд:

Дт: Орлогын албан татварын зардал
Кт: Орлогын албан татварын өглөг

Тайлант үеийн эцэст Урьдчилж төлсөн орлогын албан татварын болон Орлогын албан татварын өглөг дансдыг хооронд нь хааж, орлогын албан татварын авлага, өглөгийг тодорхойлно.

Дт: Орлогын албан татварын өглөг
Кт: Урьдчилж төлсөн орлогын албан татвар

**Орлого, зардлын нэгдсэн дансны бүртгэл**

ХЗХ нь тайлант хугацааны эцэст кредит үлдэгдэлтэй орлогын, дебет үлдэгдэлтэй зардлын дансдыг Орлого, зардлын нэгдсэн дансанд хааж, үйл ажиллагааны үр дүнг тодорхойлон хуримтлагдсан орлогын дансанд хаалтын бичилт хийнэ.

Орлогын дансдын хаалтын бичилт:

Дт: Орлогын бүх данс
Кт: Орлого, зардлын нэгдсэн данс

Зардлын дансдын хаалт:

Дт: Орлого, зардлын нэгдсэн данс
Кт: Зардлын бүх данс

ХЗХ ашигтай ажилласан бол:

Дт: Орлого, зардлын нэгдсэн данс
Кт: Цэвэр орлого

ХЗХ алдагдалтай ажилласан бол:

Дт: Цэвэр алдагдал
Кт: Орлого, зардлын нэгдсэн данс

Орлого, зардлын нэгдсэн дансны хаалтын бичилтүүд нь ХЗХ-ны Баланс болон Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлангийн хоорондын уялдааг хангаж, хөрөнгө, түүний эх үүсвэрийг тохируулахад ашиглана.

ХЗХ нь салбартай бол салбарт хаалтын гүйлгээг дээрхийн адил хийж оны цэвэр орлого, алдагдлыг төвийн "Цэвэр орлого" дансанд хааж бичнэ.

Салбарт:

Салбар ашигтай ажилласан бол:

Дт: Цэвэр орлого
Кт: Салбар хоорондын тооцоо

Салбар алдагдалтай ажилласан бол:

Дт: Салбар хоорондын тооцоо
Кт: Цэвэр алдагдал

Төвд:

Салбар ашигтай ажилласан бол:

Дт: Салбар хоорондын тооцоо
Кт: Хуримтлагдсан орлого

Салбар алдагдалтай ажилласан бол:

Дт: Хуримтлагдсан алдагдал
Кт: Салбар хоорондын тооцоо

Нийт ХЗХ-ны хэмжээнд ашигтай ажилласан бол дараа оны эхний өдөр:

Дт: Цэвэр орлого
Кт: Хуримтлагдсан орлого

Нийт ХЗХ-ны хэмжээнд алдагдалтай ажилласан бол:

Дт: Хуримтлагдсан орлого
Кт: Цэвэр алдагдал

**Ердийн бус (онцгой шинжтэй) зүйлс**

ХЗХ-ны ердийн үйл ажиллагаанаас илт ялгаатай үйл явдал, ажил гүйлгээнээс үүсдэг байнга давтагдан гарахгүй орлого ба зардлыг ердийн бус орлого, зардал гэнэ. Тухайлбал байгалийн гамшиг болон гэнэтийн ослоос үүссэн гарз хохирол гэх мэт.

Онцгой шинжтэй зүйлийн шинж чанар болон дүнг Үйл ажиллагааны үр дүнгийн тайланд тусгахдаа ердийн үйл ажиллагааны үр дүнгээс тусгаарлан, тайлант үеийн цэвэр орлогод оруулж тооцно.

## ЗУРГАА. ГАДААД ВАЛЮТААР ИЛЭРХИЙЛЭГДСЭН ӨГЛӨГИЙН БҮРТГЭЛ

### 6.1 Валютын ханшийн зөрүү

#### 6.1.1 Ханшийн тэгшитгэл

Ханшийн зөрүүг хүлээн зөвшөөрөх

Гадаад валютаар илэрхийлэгдсэн өглөгийн тооцоог тайлагнах үед тэдгээрийг анх бүртгэсэн үеийн эсвэл өмнөх үед тайлагнасан ханшаас ялгаатайгаар үүссэн ханшийн

зөрүүг тайлант үеийн олз, гарзаар хүлээн зөвшөөрнө. Өөрөөр хэлбэл ХЗХ-ны баланс дахь гадаад валютаар илэрхийлэгдсэн өглөгийг нэрлэсэн үнээр нь бүртгэн, үлдэгдэлд Монголбанкнаас зарласан ханшаар тухай бүр ханшийн тэгшитгэл хийж тайлант хугацааны цэвэр орлогод оруулна. Эдгээрт дараах зүйлс орно.

- Гадаад валютаар авсан зээл
- Гадаад валютын бусад өглөг

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш буурсан тохиолдолд ХЗХ-ны гадаад валютаар илэрхийлэгдсэн өглөгийн дансанд Монголбанкнаас ханш зарласан тухай бүр ханшийн тэгшитгэл хийж, өглөгийн дансны хуучин, шинэ үнэлгээний зөрүүгээр бүртгэлд тусгана.

Дт: Гадаад валютын ханшийн зөрүүний гарз
Кт: Гадаад валютаар илэрхийлэгдэх өглөг

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш өссөн тохиолдолд:

Дт: Гадаад валютаар илэрхийлэгдэх өглөг
Кт: Гадаад валютын ханшийн зөрүүний олз

# ДОЛОО. ТҮРЭЭСИЙН БҮРТГЭЛ

## 7.1 Түрээс

### 7.1.1 Түрээст хамрагдах зүйл

Түрээс гэдэг нь түрээслүүлэгч зөвшөөрсөн хугацаанд хөрөнгө ашиглах эрхээ тодорхой төлбөртэйгээр түрээслэгчид шилжүүлэх хэлцэл юм.

### 7.1.2 Түрээсийн ангилал

**Санхүүгийн түрээс:** Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бараг бүх эрсдэл болон урамшууллыг шилжүүлэх нөхцөл бүхий түрээс юм. Өмчлөх эрх шилжих эсвэл шилжихгүй байж болно.

**Үйл ажиллагааны түрээс:** Санхүүгийн түрээсээс бусад түрээс юм.

### 7.1.3 Түрээсийн хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэх

а. Түрээсийн хугацааны эцэст түрээс нь хөрөнгө өмчлөх эрхийг түрээслэгчид шилжүүлдэг байх;
б. Сонголтын эрх хэрэгжих өдрийн бодит үнэ цэнээс мэдэгдэхүйц бага үнээр уг хөрөнгийг түрээслэгч нь худалдан авах сонголтын эрхтэй учир уг сонголтын эрх хэрэгжих нь ул үндэслэлтэйгээр түрээсийн эхэнд тодорхой болсон байх;
в. Хэдийгээр эрх нь шилжээгүй байсан ч түрээсийн хугацаа нь хөрөнгийн ашиглалтын хугацааны ихэнх хугацаа байх;
г. Түрээсийн эхэнд тогтоосон түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ нь уг түрээслэсэн бараг бүх бодит үнэ цэнэтэй наад зах нь дүйцэж байх;
д. Зөвхөн түрээслэгч ямар нэг томоохон өөрчлөлт хийхгүйгээр ашиглаж болох онцгой шинж чанар бүхий түрээслэсэн хөрөнгө

гэсэн шалгуурыг хангаж байвал санхүүгийн түрээс гэж ангилна.

Түрээслүүлэгч нь санхүүгийн орлогыг түрээсийн хугацаанд системчилсэн, зохих сууриар хуваарилна.

**А. Санхүүгийн түрээс**

**Түрээслүүлэгчийн бүртгэл.**

Түрээслүүлэгч нь санхүүгийн түрээсийн дагуу эзэмшиж буй хөрөнгийг балансд хүлээн зөвшөөрч, тэдгээрийг түрээст оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын дүнтэй тэнцүү дүнгээр авлага гэж бүртгэх ёстой.

Түрээсийн гэрээгээр хөрөнгийг шилжүүлэх үед өнөөгийн үнэ цэнээр:

Дт: Санхүүгийн түрээсийн авлага
Кт: Үндсэн хөрөнгө
Кт: Санхүүгийн хэрэгжээгүй орлого

Түрээсийн төлбөрийг хүлээн авах үед:

Дт: Мөнгөн хөрөнгийн данс
Кт: Санхүүгийн түрээсийн авлага
Кт: Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого

Түрээсийн хөрөнгийг цуглуулсан хэмжээгээр санхүүгийн хэрэгжээгүй орлогыг зохих сууриар хуваарилж, санхүүгийн орлого болгон тайлагнасан дүнгээр:

Дт: Санхүүгийн хэрэгжээгүй орлого
Кт: Санхүүгийн түрээсийн орлого

Түрээсийн хугацааны эцэст уг түрээсэлсэн хөрөнгөө түрээслэгч талд худалдсан бол:

Дт: Мөнгөн хөрөнгийн данс
Кт: Түрээсийн хөрөнгө борлуулсны олз

**Түрээслэгчийн бүртгэл**

Түрээслэгч нь санхүүгийн түрээсийг балансын хөрөнгө ба өр төлбөрийн хэсэгт түрээсийн үүслийн үеэрх түрээсийн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар бүртгэж тусгана. Түрээслэгчийн аливаа анхдагч шууд зардлуудыг хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн дүнд нэмнэ.

Түрээсийн гэрээгээр хөрөнгийг хүлээн авах үед:

Дт: Түрээслэн авсан хөрөнгө
Кт: Санхүүгийн түрээсийн өглөг

Түрээсийн төлбөрийг төлөх үед:

Дт: Санхүүгийн түрээсийн өглөг
Дт: Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал

Кт: Мөнгөн хөрөнгийн данс

**Б. Үйл ажиллагааны түрээс**

**Түрээслүүлэгчийн бүртгэл**

Өөр суурь нь түрээслэсэн хөрөнгийн өгөөжийн бууралтыг илүү сайн илэрхийлэх цаг хугацааны хэв загвар болж чадахааргүй бол үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар орлого болгон хүлээн зөвшөөрөх ёстой.

Түрээсийн төлбөрийг хуримтлуулж бүртгэх буюу мөнгөөр хүлээж авсан үед:

Дт: Авлага эсвэл Мөнгөн хөрөнгийн данс
Кт: Түрээсийн орлого

Үйл ажиллагааны түрээсийн хэлэлцээр хийх, тохиролцохтой холбоотойгоор түрээслүүлэгчээс гарсан анхдагч шууд зардлыг түрээслэсэн хөрөнгийн дансны үнэ дээр нэмж, түрээсийн орлогыг хүлээн зөвшөөрсөнтэй ижил сууриар түрээсийн хугацааны туршид зардлаар хүлээн зөвшөөрнө.

**Түрээслэгчийн бүртгэл**

Өөр суурь нь хэрэглэгчийн өгөөжийн цаг хугацааны хэв загварыг илүү сайн илэрхийлэхгүй бол түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар зардлаар хүлээн зөвшөөрвөл зохино.

Түрээсийн төлбөрийг хуримтлуулж бүртгэх буюу төлөх үед:

Дт: Түрээсийн зардал
Кт: Өглөг эсвэл Мөнгөн хөрөнгийн данс

## НАЙМ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АЛДАА

8.1 ХЗХ өмнөх тайлант үеийн материаллаг алдааг илрүүлсэн тайлант үед дараах байдлаар санхүүгийн тайланд буцаан мөрдөх горимын дагуу залруулна:

а. Алдаа гарсан өмнөх тайлант үед толилуулсан дүнтэй зэрэгцүүлэгдэх дүнг дахин тайлагнах;

б. Хамгийн эхний өмнөх үеүдэд толилуулахаас өмнө алдаа гарсан бол хамгийн эхний өмнөх үеийн хөрөнгө, өр төлбөр ба өөрийн хөрөнгийн эхний үлдэгдлийг дахин тайлагнана.

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 232/216 дугаартай хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт

## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ДАНСНЫ ЖАГСААЛТ

## А. БАЛАНС

| ДАНСНЫ ҮНДСЭН АНГИЛАЛ | ДАНСНЫ ДУГААР | ДАНСНЫ НЭР |
|---|---|---|
| | | **НЭГ. ХӨРӨНГӨ** |
| | | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ |
| **10-11** | | ***МӨНГӨН ХӨРӨНГӨ*** |
| | | БЭЛЭН МӨНГӨ |
| | 1001 | Бэлэн мөнгө |
| | 1002 | Жижиг мөнгөн сан |
| | | |
| | | БАНКИНД БАЙРШУУЛСАН ХАРИЛЦАХ |
| | 1110 | Банкин дахь харилцах данс |
| | 1112 | Бусад санхүүгийн байгууллага дахь харилцах данс |
| | | |
| | | БАНКИНД БАЙРШУУЛСАН ХАДГАЛАМЖ |
| | 1120 | Банкин дахь хугацаагүй хадгаламж |
| | 1122 | Банкин дахь хугацаатай хадгаламж |
| | | |
| **12** | | ***ЗЭЭЛ*** |
| | | ХЭВИЙН ЗЭЭЛ |
| | 1210 | Хэвийн зээл |
| | | |
| | | ХУГАЦАА ХЭТЭРСЭН ЗЭЭЛ |
| | 1220 | Хугацаа хэтэрсэн зээл |
| | | |
| | | ХЭВИЙН БУС ЗЭЭЛ |
| | 1230 | Хэвийн бус зээл |
| | | |
| | | ЭРГЭЛЗЭЭТЭЙ ЗЭЭЛ |
| | 1240 | Эргэлзээтэй зээл |
| | | |
| | | МУУ ЗЭЭЛ |
| | 1250 | Муу зээл |
| | | |
| | 1260 | Зээлийн эрсдэлийн сан |
| | | |
| **13** | | ***БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ*** |
| | 1301 | Арилжааны үнэт цаас |
| | | |
| **14** | | ***ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ*** |
| | 1401 | Өмчлөх бусад хөдлөх хөрөнгө |

| | | |
|---|---|---|
| | 1402 | Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө |
| | 1403 | Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга |
| | | |
| **15** | | ***БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ*** |
| | 1501 | Байгууллага, хувь хүмүүсээс авах авлага |
| | 1502 | Татварын авлага |
| | 1503 | Урьдчилж төлсөн тооцоо |
| | 1504 | Дараа тайлангийн тооцоо |
| | 1505 | Дутагдал, шамшигдал |
| | 1506 | Хангамжийн зүйлс |
| | 1507 | Урьдчилж төлсөн түрээсийн зардал |
| | 1508 | Урьдчилж төлсөн даатгалын зардал |
| | 1509 | Урьдчилж төлсөн орлогын албан татвар |
| | | |
| | | ***САЛБАР ХООРОНДЫН ТООЦОО*** |
| | 1510 | Салбар хоорондын авлага |
| | | |
| | | ***ХУРИМТЛУУЛЖ ТООЦСОН ХҮҮГИЙН АВЛАГА*** |
| | 1520 | Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага |
| | 1530 | Хуримтлуулж тооцсон хадгаламжийн хүүгийн авлага |
| | 1540 | Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн авлага |
| | 1550 | Санхүүгийн түрээсийн хүүгийн авлага |
| | | |
| | | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ |
| **20** | | ***ҮНДСЭН ХӨРӨНГӨ*** |
| | 2001 | Газар |
| | 2002 | Барилга |
| | 2003 | Тавилга, эд хогшил |
| | 2004 | Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж |
| | 2005 | Компьютер, дагалдах хэрэгсэл |
| | 2006 | Үндсэн хөрөнгийн санхүүжилт |
| | 2007 | Бусад үндсэн хөрөнгө |
| | | |
| | | ***ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ*** |
| | 2010 | Хуримтлагдсан элэгдэл: Барилга |
| | 2011 | Хуримтлагдсан элэгдэл: Тавилга, эд хогшил |
| | 2012 | Хуримтлагдсан элэгдэл: Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж |
| | 2013 | Хуримтлагдсан элэгдэл: Компьютер, дагалдах хэрэгсэл |
| | 2014 | Бусад үндсэн хөрөнгийн элэгдэл |
| | 2015 | Биет бус хөрөнгийн элэгдэл |
| | | |
| **21** | | ***БИЕТ БУС ХӨРӨНГӨ*** |
| | 2101 | Патент |
| | 2102 | Зохиогчийн эрх |
| | 2103 | Програм хангамж |
| | 2104 | Франчайз |
| | 2105 | Бусад биет бус хөрөнгө |
| | | |
| **22** | | ***ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ*** |
| | 2201 | Урт хугацаат өрийн бичиг |

| | | |
|---|---|---|
| | 2202 | Бусад урт хугацаат хөрөнгө оруулалт |
| | 2210 | Хойшлогдсон татварын хөрөнгө |
| | | **ХОЁР. ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** |
| **31** | | ӨР ТӨЛБӨР |
| | | **ХАДГАЛАМЖ** |
| | | ***ХУГАЦААГҮЙ ХАДГАЛАМЖ*** |
| | 3101 | Хугацаагүй хадгаламж |
| | 3105 | Идэвхгүй гишүүний хугацаагүй хадгаламж |
| | | |
| | | ***ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ*** |
| | 3110 | Хугацаатай хадгаламж |
| | | |
| | | ***БАНК БУС НЭГЖИД ТӨЛӨХ ӨГЛӨГ*** |
| | 3120 | Төсөл, хөтөлбөрийн зээл |
| | 3121 | Тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа |
| | | |
| | | ***БАНКНААС АВСАН ЗЭЭЛ*** |
| | 3130 | Банкнаас авсан богино хугацаат зээл |
| | 3131 | Банкнаас авсан урт хугацаат зээл |
| | | |
| | | ***САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ*** |
| | 3140 | Санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл |
| | 3141 | Санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл |
| | | |
| | | ***БУСАД ӨГЛӨГ*** |
| | 3150 | Цалингийн өглөг |
| | 3151 | Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн өглөг |
| | 3152 | Хувь хүний орлогын албан татварын өглөг |
| | 3153 | Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого |
| | 3154 | Орлогын албан татварын өглөг |
| | 3155 | Ногдол ашгийн өглөг |
| | 3156 | Идэвхгүй гишүүний ногдол ашгийн өглөг |
| | 3157 | Санхүүгийн түрээсийн өглөг |
| | 3158 | Бусад өр төлбөр |
| | 3159 | Хойшлогдсон татварын өр төлбөр |
| | | |
| | | ***САЛБАР ХООРОНДЫН ТООЦОО*** |
| | 3160 | Салбар хоорондын тооцоогоорх өглөг |
| | | |
| | | ***ХУРИМТЛУУЛЖ ТООЦСОН ХҮҮГИЙН ӨГЛӨГ*** |
| | 3170 | Хуримтлуулж тооцсон хадгаламжийн хүүгийн өглөг |
| | 3171 | Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг |
| | 3172 | Санхүүгийн түрээсийн хүүгийн өглөг |
| | | |
| **32** | | ***УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО*** |
| | 3201 | Урьдчилж орсон зээлийн хүүгийн орлого |
| | 3202 | Урьдчилж орсон санхүүгийн түрээсийн орлого |
| | | |
| **41** | | ӨӨРИЙН ХӨРӨНГӨ |
| | | ***ГИШҮҮНИЙ ОРУУЛСАН ХУВЬ ХӨРӨНГӨ*** |
| | 4101 | Гишүүний оруулсан хувь хөрөнгө |

| | | |
|---|---|---|
| | 4110 | Идэвхгүй гишүүний оруулсан хувь хөрөнгө |
| | 4120 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл |
| | | |
| | | ***ХАНДИВ, ТУСЛАМЖ*** |
| | 4130 | Хандив |
| | 4131 | Тусламж |
| | | |
| | | ***САНГУУД*** |
| | 4140 | Нөөцийн сан |
| | 4141 | Хадгаламж хамгаалалтын сан |
| | 4142 | Нийгмийн хөгжлийн сан |
| | 4143 | Бусад сан |
| | | |
| | | ***ХУРИМТЛАГДСАН ОРЛОГО (АЛДАГДАЛ)*** |
| | 4150 | Цэвэр орлого (алдагдал) |
| | 4160 | Хуримтлагдсан орлого (алдагдал) |

## Б. ОРЛОГО, ЗАРДЛЫН ДАНС

| | | |
|---|---|---|
| | | **НЭГ. ОРЛОГО** |
| **51** | | ***ХҮҮГИЙН ОРЛОГО*** |
| | 5101 | Зээлийн хүүгийн орлого |
| | 5102 | Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого |
| | 5110 | Үнэт цаасны хүүгийн орлого |
| | 5120 | Банкнаас авсан хүүгийн орлого |
| | 5130 | Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого |
| | 5140 | (Зээлийн хүүгийн орлогын буцаалт) |
| | | |
| | | ***ХҮҮГИЙН БУС ОРЛОГО*** |
| | 5141 | Элсэлтийн хураамж |
| | 5142 | Гишүүний татвар |
| | 5143 | Үйлчилгээний шимтгэл, хураамж |
| | 5144 | Түрээсийн орлого |
| | 5150 | Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээний орлого |
| | | |
| | | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО, ОЛЗ** |
| | 5181 | Үндсэн хөрөнгө борлуулсны олз |
| | 5182 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз |
| | 5183 | Үнэт цаасны арилжааны орлого |
| | 5184 | Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого |
| | 5185 | Торгуулийн орлого |
| | 5190 | Бусад орлого |
| | | |
| | | **ХОЁР. ЗАРДАЛ** |
| **70** | | ***ХҮҮГИЙН ЗАРДАЛ*** |
| | 7001 | Хадгаламжийн хүүгийн зардал |
| | 7002 | Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал |
| | 7003 | Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал |
| | 7004 | Бусад хүүгийн зардал |
| | 7010 | Хүүгийн зардлын буцаалт |

| | | |
|---|---|---|
| | | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ |
| | | ***БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ*** |
| | 7021 | Зээлийн эрсдэлийн зардал |
| | 7022 | Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын гарз |
| | 7030 | Болзошгүй эрсдэлийн зардлын нөхөлт |
| | | |
| | | ***БОЛОВСОН ХҮЧНИЙ ХОЛБОГДОЛТОЙ ЗАРДАЛ*** |
| | 7041 | Ажилтнуудын цалингийн зардал |
| | 7042 | Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл |
| | 7043 | Ажиллагсдын сургалтын зардал |
| | 7044 | Гэрээт ажиллагсдын цалингийн зардал |
| | 7045 | Ажилтнуудад олгосон нөхөн олговрын зардал |
| | 7046 | Ажилтнуудад олгосон нэмэгдэл, хөнгөлөлтийн зардал |
| | 7047 | Боловсон хүчний бусад зардал |
| | | |
| | | ***БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ*** |
| | 7050 | Зээл болон бусад авлагыг барагдуулахтай холбогдолтой зардал |
| | 7051 | ХЗХ-дын Үндэсний Холбооны гишүүний татвар |
| | 7052 | Тогтворжилтын үйлчилгээний шимтгэл |
| | 7053 | Аудит, мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардал |
| | 7054 | Франчайзийн хураамж |
| | 7055 | Даатгалын зардал |
| | 7056 | Улсын тэмдэгтийн хураамж |
| | 7057 | Хадгаламжийн даатгалын хураамж |
| | 7058 | Зохицуулалтын үйлчилгээний хөлс |
| | 7059 | Элэгдэл, хорогдлын зардал |
| | 7060 | Түрээсийн зардал |
| | 7061 | Ашиглалтын зардал |
| | 7062 | Үндсэн хөрөнгийн засварын зардал |
| | 7063 | Бичиг хэргийн зардал |
| | 7064 | Харуул, аюулгүй байдлын зардал |
| | 7065 | Шуудан, холбооны зардал |
| | 7066 | Зочин, төлөөлөгчийн зардал |
| | 7067 | Шатахуун, тээврийн зардал |
| | 7068 | Захиалгат хэвлэлийн зардал |
| | 7079 | Ариун цэврийн зардал |
| | 7070 | Газрын төлбөр |
| | 7071 | Гишүүдийн сургалт, судалгааны зардал |
| | 7072 | Албан томилолтын зардал |
| | 7073 | Хурал зохион байгуулах зардал |
| | 7074 | Өмчлөх бусад хөрөнгийн урсгал зардал |
| | 7075 | Үйл ажиллагааны бусад зардал |
| | | |
| | | **БУСАД ЗАРДАЛ, ГАРЗ** |
| | 7080 | Торгуулийн зардал |
| | 7081 | Үндсэн хөрөнгө борлуулсны гарз |
| | 7082 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз |
| | 7083 | Үнэт цаасны арилжааны алдагдал |
| | 7084 | Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн зардал |
| | 7085 | Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны гарз |

| | | |
|---|---|---|
| | 7086 | Өмчлөх бусад хөрөнгийг данснаас хассаны гарз |
| | 7087 | Хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарз |
| | 7088 | Хөрөнгийн дахин үнэлгээний гарз |
| | 7089 | Бусад зардал |
| | | |
| **91** | **9101** | ***ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ*** |
| | | |
| **92** | **9200** | ***ОРЛОГО ЗАРЛАГЫН НЭГДСЭН ДАНС*** |
| | | |

## В. БАЛАНСЫН ГАДУУРХ ДАНС

| | | |
|---|---|---|
| **99** | 9901 | Хүлээж болзошгүй үүрэг: Батлан даалт |
| | 9902 | Хүлээж болзошгүй үүрэг: Зээлийн барьцаа хөрөнгө |
| | 9903 | Хүлээж болзошгүй үүрэг: Зээлийн шугам |
| | 9910 | Үнэ бүхий зүйл: Нарийн бүртгэлийн маягтууд |
| | 9911 | Үнэ бүхий зүйл: Хадгалсан үнэ бүхий зүйлс |
| | 9915 | Хэрэглэж буй тэмдгүүд |
| | 9920 | Зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээл |
| | 9921 | Зээлийн хүүгийн тооцоо: Хуримтлуулж тооцохыг зогсоосон зээлийн хүү |

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн ...216 дугаартай хамтарсан тушаалын 3 дугаар хавсралт

# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ АРГАЧЛАЛ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1. ХЗХ нь жилийн санхүүгийн тайланг "А" маягтаар, улирлын санхүүгийн тайланг "Б" маягтаар гаргана.
2. Санхүүгийн тайлан, тодруулгын үзүүлэлтийг төгрөг, мөнгөөр илэрхийлнэ.
3. Санхүүгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэг, хариуцлагыг ХЗХ-ны удирдлага хүлээнэ.
4. Бүртгэлийн мэдээлэл боловсруулах үе шат нь анхан шатны баримт бүрдүүлэх, журналд бичих, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, ажил гүйлгээний мэдээ гаргах, санхүүгийн тайлан гаргах гэсэн дэс дараалалтай байна.

### 1. Санхүүгийн тайлангийн зорилт

Санхүүгийн тайлангийн зорилт нь гадны болон дотоодын хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад нь зориулан тухайн ХЗХ-ны санхүүгийн байдал (хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгө), үйл ажиллагааны үр дүн (орлого, үр дүн), санхүүгийн байдлын өөрчлөлт (мөнгөн гүйлгээ)-ийн талаарх мэдээллээр хангахад чиглэгдэнэ.

### 2. Санхүүгийн тайланг бэлтгэх зарчим

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах ерөнхий зарчмыг баримтална. Үүнд:

1. ХЗХ нь санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээгээ Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бодитойгоор илэрхийлсэн байх;
2. ХЗХ-г татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмаар гаргах;
3. ХЗХ нь мөнгөн гүйлгээний тайлангаас бусад санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэх;
4. Санхүүгийн тайлан дахь толилуулга ба ангиллыг нэг үеэс дараагийн үед тогтвортой хадгалах;
5. ХЗХ-ны санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад байгууллагын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэх боломжтой байх;
6. Санхүүгийн тайланд материаллаг зүйлсийг тусад нь толилуулна. Материаллаг бус дүнтэй зүйлсийг шинж чанар буюу үүргийнх нь дагуу ижил зүйлсийн дүнтэй нэгтгэн толилуулах.

### 3. Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн

1. Санхүүгийн тайлан доорх бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

- Баланс /Санхүүгийн байдлын тайлан/
- Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан /Орлогын дэлгэрэнгүй тайлан/
- Өмчийн өөрчлөлтийн тайлан

- Мөнгөн гүйлгээний тайлан
- Бусад нэмэлт тодруулга /Санхүүгийн тайлангийн тодруулга/

2. Жилийн эцсийн санхүүгийн тайланг тодруулгатай бэлтгэнэ.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран баталсан дэлгэрэнгүй заавар, аргачлалыг дагуу боловсруулна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЛАНС

### 4. Баланс

ХЗХ-ны санхүүгийн байдлыг тодорхой нэг хугацаагаар (улирал, жил) тасалбар болгон тайлагнахын тулд хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээг мөнгөн илэрхийллээр үзүүлж, балансt тусгана.

### 5. Балансын ангилал, түүнийг бэлтгэх

А) Хөрөнгийг дараах байдлаар ангилна.

- Эргэлтийн хөрөнгө
- Эргэлтийн бус хөрөнгө

1. Хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийг балансд нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан үнэлгээгээр үнэлж үзүүлнэ.
2. Хөрөнгийг хөрвөх чадвараар нь, өр төлбөрийг төлөгдөх хугацаагаар нь дэс дараалуулан балансад тусгана.

### 6. Эргэлтийн хөрөнгө

ХЗХ-ны үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд ашиглахаар эзэмшиж байгаа эсвэл борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө, тайлант өдрөөс хойш 12 сарын дотор өр төлбөрийг барагдуулахад ашиглах мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгө нь эргэлтийн хөрөнгөд хамаарна.

Эргэлтийн хөрөнгийг балансд дараах байдлаар ангилан толилуулна. Үүнд:

1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө:

   а. Бэлэн мөнгө
   б. Банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, тусгай зориулалт бүхий мөнгөн сан, мөнгөтэй адилтгах бусад зүйлс
   в. Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж хамаарна.

   Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

2. Богино хугацаат хөрөнгө оруулалт:

   Арилжааны үнэт цаас хамаарна.

   Богино хугацаат хөрөнгө оруулалтыг өртгөөр нь бүртгэнэ.

3. Зээл, авлага:

а. Зээл
б. Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага
в. Санхүүгийн түрээсийн авлага
г. Байгууллага, хувь хүмүүсээс авах авлага
д. Дутагдал, шамшигдал
е. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага
ё. Бусад авлага хамаарна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, бусад татвар, төлбөр, хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна. Бусад авлагад нэг хүртэлх жилийн хугацаатай буюу үйл ажиллагааны нэг циклийн дотор эргэн төлөгдөх үндсэн үйл ажиллагаатай холбогдолгүй үүссэн авлага хамаарна.

Зээлийн дүнгээс Зээлийн эрсдэлийн санг хасч цэвэр дүнгээр, авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь балансд тусгана.

4. Өмчлөх бусад хөрөнгө:

Өмчлөх бусад хөрөнгийн өртгөөс түүний үнэлгээний хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр нь балансд тусгана.

5. Бусад эргэлтийн хөрөнгө:

- Хангамжийн зүйлс
- Урьдчилж төлсөн зардал, тооцоо хамаарна.

Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зардлыг (даатгал, түрээс гэх мэт) балансын хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зардлыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ. Хангамжийн зүйлс, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

Хангамжийн зүйлсийг өртгөөр нь, урьдчилж төлсөн зардал, тооцоог төлсөн дүнгээр нь бүртгэнэ.

## 7. Эргэлтийн бус хөрөнгө

Эргэлтийн хөрөнгөөс бусад бүх хөрөнгө нь эргэлтийн бус хөрөнгөд хамрагдана.

Эргэлтийн хөрөнгийг балансд дараах байдлаар ангилан толилуулна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө:

Нэгээс дээш тайлант хугацаанд үйлчилгээ үзүүлэхэд болон удирдлагын хэрэгцээнд ашиглаж байгаа биет зүйлс үндсэн хөрөнгөд хамаарна.

Үндсэн хөрөнгийг балансд хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна.

Үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн хөрөнгийн дансны үнэ болон түүнтэй адил төстэй хөрөнгийн өнөөгийн зах зээлийн үнэ хоёрын хоорондох зөрүүгээр хэмжинэ.

2. Биет бус хөрөнгө

Биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөөр илэрхийлэгдээгүй хөрөнгө биет бус хөрөнгөд хамаарна.

Биет бус хөрөнгийг балансд анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр нь тусгана.

3. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат өрийн бичгийг өртгөөр нь балансад тусгана.

4. Хойшлогдсон татварын хөрөнгө

Хойшлогдсон татварын хөрөнгөд хасагдах түр зөрүү болон ашиглагдаагүй татварын алдагдлыг дараагийн үе рүү шилжүүлэхтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед нөхөгдөх орлогын албан татварын дүн хамаарна.

ХЗХ нь хасагдах түр зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед л хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хэрэв хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг ашиглах хангалттай хэмжээний татвар ногдуулах орлого олох магадлалгүй бол тэр хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулна. Энэхүү бууралтыг хангалттай хэмжээний татвар ногдуулах орлого олох магадлалтай болсон үед буцаана.

Б) Өр төлбөрийг дараах байдлаар ангилна.

- Богино хугацаат өр төлбөр
- Урт хугацаат өр төлбөр

## 8. Богино хугацаат өр төлбөр

ХЗХ-ны үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд төлбөр нь барагдахаар хүлээгдэж байгаа эсвэл тайлангийн өдрөөс хойш 12 сарын дотор барагдуулах ёстой өр төлбөрийг богино хугацаат өр төлбөр гэнэ. Богино хугацаат өр төлбөрийг төлөгдөх дүнгээр нь бүртгэж балансд дараах байдлаар ангилан харуулна. Үүнд:

1. Хадгаламж:

Бүх төрлийн хадгаламжийн дансны үлдэгдлийг өнөөгийн үнэ цэнээр балансд тусгана.

Санхүүгийн жилийн эцэст хугацаагүй хадгаламжид хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийг хадгаламжийн үндсэн үлдэгдэлд нэмэгдүүлж бүртгэнэ.

2. Банк, санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөрөөс авсан богино хугацаат зээл:

Банк, санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийг өнөөгийн үнэ цэнээр балансд тусгана.

3. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг:

Богино болон урт хугацаат зээлтэй холбоотой үүссэн, төлөгдөөгүй байгаа хүүгийн төлбөрийн дүнг тусгана.

4. Цалингийн өглөг

Ажилчдад өгөх цалин, бусад хэлбэрийн хөдөлмөрийн хөлсний өглөгийг энэ хэсэгт тусгана.

5. Татвар, НДШ-ийн өглөг

Татварын хуулийн дагуу тооцсон, тухайн тайлант хугацааны эцэст төсөвт төлөөгүй байгаа татварын дүнг энд тусгана. Улирал ба жилийн эцэс дэх төлөгдөөгүй татварын үлдэгдэл нь татварын байгууллагаас баталгаажуулсан үлдэгдэлтэй тэнцүү байна.

Цалингаас суутгасан болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцэс дэх төлөгдөөгүй үлдэгдлийг тооцон энэ хэсэгт тусгана.

6. Ногдол ашгийн өглөг

Бүх гишүүдийн хурлын шийдвэрээр гишүүдэд толохоор зарласан ногдол ашгийг энэ дансаар бүртгэж тайлагнана. Зөвхөн мөнгөн хэлбэрийн ногдол ашгийн тайлант хугацааны эцэс дэх төлөгдөөгүй үлдэгдлийг богино хугацаат өр төлбөр гэж үзнэ.

7. Урьдчилж орсон орлого:

Зээл ашиглагдаагүй байх үед зээлийн хүүг болон ажил, үйлчилгээ үзүүлэхээс өмнө орлогыг урьдчилан хүлээн авсан тохиолдолд хүлээн авсан мөнгөний хэмжээгээр богино хугацаат өр үүсгэж, энэ дансанд бүртгэнэ. Энэ дансыг үйлчилгээ үзүүлсэн буюу орлого хэрэгжсэн үед дебитлэж, холбогдох орлогын дансыг кредитлэнэ.

8. Бусад богино хугацаат өр төлбөр:

Үйл ажиллагааны явцад бэлтгэн нийлүүлэгчээс зээлээр худалдан авсан хангамжийн зүйлс, ажил гүйцэтгэгчид төлөөгүй ажлын хөлс, тогтворжилтын сангаас авсан санхүүгийн туслалцаа болон бусад богино хугацаат өглөгийг энэ дансанд тусгана.

## 9. Урт хугацаат өр төлбөр

Богино хугацаатай өр төлбөрөөс бусад өр төлбөрийг урт хугацаат өр төлбөрт хамруулна. Урт хугацаат өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар ангилна. Үүнд:

1. Банк, санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөрөөс авсан урт хугацаат зээл:

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын байгууллагаас авсан зээлийн дүнг энэ хэсэгт толилуулна.

2. Хойшлогдсон татварын өр төлбөр:

Хойшлогдсон татварын өр гэж татвар ногдох түр зөрүүтэй холбоотойгоор ирээдүйн

тайлант үед төлөх орлогын албан татварын өрийн дүнг хэлнэ.

3. Бусад урт хугацаат өр төлбөр:

Урт хугацаат өрийн бичиг болон бусад урт хугацаат өр төлбөрийн дүнг энэ хэсэгт толилуулна.

### 10. Өөрийн хөрөнгө

Өөрийн хөрөнгө нь гишүүдийн оруулсан хувь хөрөнгө болон нөөцийн сан, хадгаламж хамгаалалтын сан, бусад сан, хандив, тусламж, хуримтлагдсан орлогын нийлбэр юм.

Өөрийн хөрөнгийг балансд дараах байдлаар ангилна. Үүнд:

1. Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийг өнөөгийн үнэ цэнээр балансд тусгана.

2. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

ХЗХ-ны үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн бол бусад орлогоор хүлээн зөвшөөрсөн өсөлтийн дүнг энэ дансанд хуримтлуулан бүртгэнэ.

3. Хоршоологчдын өмч

А. Нөөцийн сан, бусад сан

Тусгай зориулалтын сангуудыг өнөөгийн үнэ цэнээр балансд тусгана.

Б. Хандив, тусламж

В. Хуримтлагдсан орлого

ХЗХ үүсэн байгуулагдсанаас хойших хугацаанд ХЗХ-нд хуримтлагдан үлдсэн ашиг, алдагдлын нийлбэрийг хуримтлагдсан орлого дансанд бүртгэнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан нь ХЗХ-ны тодорхой хугацааны үйл ажиллагааны үр дүнг хэмжинэ.

Үйл ажиллагааны үр дүнгийн тайланд орлогыг хүлээн авсан эсвэл авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Орлоготой холбогдож гарсан зардлыг жинхэнэ гарсан хэмжээгээр нь тусгана. Энэхүү тайланд зардлыг чиг үүргээр нь ангилж үр дүнг тооцно.

### Үйл ажиллагааны үр дүнгийн тайланг бэлтгэх

1. Үйл ажиллагааны үр дүнгийн тайланг бэлтгэхдээ тухайн тайлангийн хугацаанд хамрагдах орлого, зарлагын ажил, гүйлгээг аккруэл суурьаар бүртгэнэ. Энэ зарчмаар орлогыг олсон бөгөөд хэмжих боломжтой болсон үед, зардлыг гарсан бөгөөд хэмжих

боломжтой болсон үед нь бүртгэнэ.
2. Орлого ба зардлыг тэдгээрийн үүсэн гарч буй шалтгаанаар нь ангилна. Орлогын зүйл анги тус бүрт зардлын зүйл ангийг зохицуулан бүртгэх зарчмыг баримтална.
3. Хүүгийн орлогын буцаалт, хүүгийн зардлын буцаалтыг холбогдох орлого, зардлаас хасч, тайланд цэвэршүүлж тусгана.

Дараах зүйлүүдийг үйл ажиллагааны үр дүнгийн тайланд тусгана. Үүнд:

**Хүүгийн орлого**

Зээлийн болон хадгаламжийн, санхүүгийн түрээсийн хүүгийн орлого хамаарагдана.

**Хүүгийн зардал**

Гишүүдийн хадгаламж болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал хамаарагдана.

**Хүүгийн цэвэр орлого**

Хүүгийн орлогоос хүүгийн зардлыг хасч, хүүгийн цэвэр орлогыг тодорхойлно.

**Үйл ажиллагааны бусад орлого**

Гишүүний татвар, элсэлтийн хураамж, үйлчилгээний шимтгэл, санхүүгийн бусад ажил, үйлчилгээний орлого хамаарагдана.

**Эрсдэлийн сангийн зардал**

Зээлийн эрсдэлийн зардал, өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал хамаарагдана.

**Үйл ажиллагааны цэвэр орлого**

Хүүгийн цэвэр орлого дээр үйл ажиллагааны бусад орлогыг нэмж, эрсдэлийн сангийн зардлыг хасч, үйл ажиллагааны цэвэр орлогыг тодорхойлно.

**Үйл ажиллагааны зардал**

Үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдон гарсан зардлууд хамаарагдана.

**Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)**

Гадаад валютаар илэрхийлэгдсэн зээлийн үлдэгдэлд хийгдсэн ханшийн тэгшитгэлийн олз (гарз), зарим мөнгөн бус зүйлсийн валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрсөн олз (гарз)-ыг хамруулна.

**Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)**

Үндсэн хөрөнгийг борлуулах, хандивлах эсвэл түүний ашиглалтаас ирээдүйн эдийн засгийн үр өгөөж хүртэхгүй болсон үед данснаас хасна. Үндсэн хөрөнгийн дансны үнэ болон хасалтаас олсон орлогын зөрүүгээр олз (гарз)-ыг тодорхойлно.

**Татвар төлөхийн өмнөх орлого (алдагдал)**

Үйл ажиллагааны цэвэр орлогоос үйл ажиллагааны зардлыг хасч, гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз), үндсэн хөрөнгө данснаас хассаны болон борлуулсны олз (гарз)-ыг нэмж татвар төлөхийн өмнөх орлого (алдагдал)-ыг тодорхойлно.

**Орлогын татварын зардал**

Орлогын татварын зардал (орлого) нь тайлант үеийн татварын зардал болон хойшлогдсон татварын зардал (орлого)-аас бүрдэнэ.

**Цэвэр орлого (алдагдал)**

Татвар төлөхийн өмнөх орлогоос орлогын татварын зардлыг хасч цэвэр орлогыг тодорхойлно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Өмчийн өөрчлөлтийн тайланд ХЗХ-ны гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл болон тусгай зориулалтын сангууд, хуримтлагдсан орлого зэрэг өөрийн хөрөнгийн аливаа өөрчлөлтийн хэмжээг хоёр жилээр толилуулна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулгыг хуримтлагдсан орлогын эхний үлдэгдлийг залруулах замаар тусгана.
- Өөрийн хөрөнгөд гарсан өөрчлөлтийг тухайн тайлант хугацааны эхэнд болон эцэст гэсэн байдлаар тусган харуулна.
- Хуримтлагдсан орлого (алдагдал)-ын өнгөрсөн оны үлдэгдэл дээр тайлангийн үеийн цэвэр орлогыг нэмж, алдагдлын шинжтэй тохируулах бичилт болон ногдол ашгийг хасах байдлаар тооцож, тайлангийн үеийн хуримтлагдсан орлого (алдагдал)-ын эцсийн үлдэгдлийг тодорхойлно.
- Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийг данснаас хасах үед тухайн хөрөнгийн дахин үнэлгээний хуримтлагдсан нэмэгдлийн дүнг дахин үнэлгээний нэмэгдэл гэсэн мөрөнд хуримтлагдсан орлогоос хасч тусгана.
- Хуримтлагдсан орлого (алдагдал)-ын залруулсан үлдэгдэл дээр тайлант үеийн цэвэр орлого, өмчид гарсан нэмэгдэх өөрчлөлт, дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг нэмж, тайлант үеийн цэвэр алдагдал, өмчид гарсан хасагдах өөрчлөлт болон зарласан ногдол ашгийг хасч, тайлант үеийн хуримтлагдсан орлого (алдагдал)-ын эцсийн үлдэгдлийг тодорхойлно.
- Нийт өөрийн хөрөнгийн эхний үлдэгдэл дээр нийт нэмэгдсэн өөрчлөлтийг нэмж, нийт хасагдсан өөрчлөлтийг хасч, өөрийн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг тодорхойлно.

## ТАВДУГААР БҮЛЭГ. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

